# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 08 дугаар сарын 14
№30 (1425)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

# ГАРЧИГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


| | | | |
|---|---|---|---|
| 187. | Улсын нисэхийн тухай /Шинэчилсэн найруулга/ | | 1696 |
| 188. | Хууль хүчингүй болсонд тооцох тухай | | 1730 |
| 189. | Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 1731 |
| 190. | Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 1732 |
| 191. | Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 1749 |
| 192. | Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 1751 |
| 193. | Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 1752 |
| 194. | Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 1756 |
| 195. | Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 1760 |
| 196. | Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | | 1773 |
| 197. | Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | | 1779 |
| 198. | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай | | 1781 |


## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 199. | Хуулийн төсөл буцаах тухай | Дугаар 37 | 1783 |
| 200. | Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 39 | 1784 |

| | | |
|---|---|---|
| ᠤᠳᠬᠠᠨᠤᠳ | ᠬᠤᠪᠢᠶᠠᠨᠳᠤ᠄

| | | | |
|---|---|---|---|
| ᠵᠠᠷᠯᠣᠭ | ᠳᠦ᠒᠌᠍ᠴᠢᠯᠡᠯ | ᠳᠦ᠒᠌᠍ᠴᠢᠯᠡᠯ | ᠬᠠᠪᠳᠠᠰᠤᠨ ᠳᠤᠷᠠᠬᠢ ᠳᠤ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠪᠣᠯᠣᠨ ᠳᠤᠷᠠᠬᠢ ᠳᠤ ᠪᠣᠯᠤᠭᠰᠠᠨ ᠴᠠᠭᠠ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 06 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

## УЛСЫН НИСЭХИЙН ТУХАЙ
**/Шинэчилсэн найруулга/**

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилго**

1.1.Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэр, агаарын зайд улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх, улсын нисэхийн үйл ажиллагааны удирдлага, зохицуулалт, улсын нисэхийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Улсын нисэхийн хууль тогтоомж**

2.1.Улсын нисэхийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Зэвсэгт хүчний тухай хууль[2], Иргэний нисэхийн тухай хууль,[3] энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Энэ хуулиар дараах харилцааг зохицуулна:

3.1.1.улсын нисэх, түүнд хамаарах улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын нислэгийн үйл ажиллагаа;

3.1.2.улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөнийг удирдахтай холбогдсон харилцаа.

**4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

---

[1] Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дугаарт нийтлэгдсэн.
[2] Зэвсэгт хүчний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 36 дугаарт нийтлэгдсэн.
[3] Иргэний нисэхийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2023 оны 32 дугаарт нийтлэгдсэн.

4.1.1.“аюул тулгарсан агаарын хөлөг” гэж агаарын хөлөг болон зорчигчдод аюул учирч, түүнийг нисэх баг өөрийн үйл ажиллагаагаар арилгаж чадахгүйд хүрсэн, эсхүл агаарын хөлөг холбоогүй буюу байрлал нь тодорхой бус болсон;

4.1.2.“аюулд нэрвэгдсэн агаарын хөлөг” гэж агаарын хөлөг нислэг үйлдэх, хөөрөх, буух, явгалах үед агаарын хөлөг гэмтэж, агаарын хөлөг болон зорчигчдод аюул учирч, аргагүйдсэн нөхцөлд буулт хийсэн, эсхүл бүрэн эвдэрсэн хөлгийг;

4.1.3.“байлдааны агаарын хөлөг” гэж байлдаанд ашиглах зориулалтаар зэвсэг, галт хэрэглэл, тусгай төхөөрөмжөөр тоноглогдсон агаарын хөлгийг;

4.1.4.“байлдааны үүргийн нислэг” гэж байлдааны үүрэг гүйцэтгэх, байлдааны жижүүрлэлт болон Монгол Улсын агаарын зайн аюулгүй байдлыг хангах ажиллагааны нислэгийг;

4.1.5.“захиалгат нислэг” гэж гамшиг, ослын болон бусад үед яаралтай хүний амь нас, эрүүл мэндийг аврах, тусгай үүрэг гүйцэтгэх чиглэлээр иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр үйлдэх нислэгийг;

4.1.6.“олон улсын нислэг” гэж улсын агаарын хөлгөөр Монгол Улс, гадаад улс хооронд үйлдэх нислэгийг;

4.1.7.“онцгой үүргийн нислэг” гэж Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн[4] 6.1.1, 6.1.2, 6.1.6, 6.1.7-д заасан этгээдэд үйлчлэх нислэгийг;

4.1.8.“сургууль-байлдааны нислэг” гэж бүх төрлийн буудлага, бөмбөгдөлт, пуужингийн харвалттай нислэг болон олон улсын хээрийн сургууль-дадлагын нислэгийг;

4.1.9.“сургууль-дадлагын нислэг” гэж нисэх багийн бүх төрлийн дадлага сургалт, эрх олгох нислэгийг;

4.1.10.“тусгай үүргийн нислэг” гэж тайван цагийн батлан хамгаалах нислэг, хил хамгаалалт, хилийн эрэл, тусгай ажиллагаа, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, гамшиг, осол, эрэн хайх, аврах ажиллагаа, эмнэлгийн яаралтай түргэн тусламж болон төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын ажил, үүргийг гүйцэтгэх нислэгийг;

[4] Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2024 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

4.1.11.“улсын агаарын хөлөг” гэж төрийн цэргийн, хууль сахиулах болон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагын нисэх онгоц, нисдэг тэрэг, бусад агаарын хөлгийг;

4.1.12.“улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага” гэж төрийн цэргийн, хууль сахиулах болон төрийн бусад чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагыг;

4.1.13.“улсын нисэх” гэж улсын агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхтэй холбогдсон цогц ойлголтыг;

4.1.14.“Улсын нисэхийн багц дүрэм” гэж энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан харилцааг зохицуулах эрх зүйн баримт бичгийг;

4.1.15.“цэргийн зориулалттай нисгэгчгүй нисэх хэрэгсэл” гэж цэргийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглах нисгэгчгүй болон зайнаас удирдах агаарын хөлгийг;

4.1.16.“шалгалт, туршилтын нислэг” гэж агаарын хөлгийг агаар болон газарт шалгах, засвар, техникийн үйлчилгээ, тоног төхөөрөмж суурилуулсны дараа хийх нислэгийг.

4.2.Нисэхийн үйл ажиллагаатай холбоотой энэ хуулиар зохицуулаагүй бусад нэр томьёог Иргэний нисэхийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан утгаар хэрэглэнэ.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## УЛСЫН НИСЭХИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

### 5 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх

5.1.Монгол Улсын Их Хурал улсын нисэхийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооно.

### 6 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

6.1.Засгийн газар улсын нисэхийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.улсын нисэхийг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, улсын нисэхийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;

6.1.2.улсын нисэхийн эрэн хайх, аврах ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээг чиглүүлэх;

6.1.3.улсын нисэхийн аэродром байгуулах, өөрчлөх, шилжүүлэх, татан буулгах, хамтран ашиглах асуудлыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын санал болгосноор Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн шийдвэрлэх;

6.1.4.улсын нисэхийн нисгэгч, инженер, техникч болон нисэхийн тусгай мэргэжлийн жагсаалт, тэдний хөдөлмөрийн хөлсний ерөнхий үнэлгээ, тусгай нэмэгдлийг тогтоох.

**7 дугаар зүйл.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

7.1.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.Улсын нисэхийн багц дүрмийг батлах;

7.1.2.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ерөнхий шинжээчийг томилох, чөлөөлөх;

7.1.3.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комиссын дүрмийг батлах;

7.1.4.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комиссыг томилох;

7.1.5.батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын улсын нисэхийн хяналтын байцаагч нисгэгч, инженерт хяналт шалгалт явуулах эрх олгох;

7.1.6.энэ хуулийн 15.2, 17.2-т заасан журмыг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;

7.1.7.улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын нисгэгч, нисэхийн тусгай мэргэжлийн бүрэлдэхүүний нислэгийн цагийн үнэлгээ, зэрэг, зэрэглэлийн нэмэгдлийг тогтоох.

**8 дугаар зүйл.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг**

8.1.Улсын нисэхийн үйл ажиллагаа батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хяналтад байна.

8.2.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.2.1.улсын нисэхийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангах;

8.2.2.улсын нисэхийн хяналт, зохицуулалтыг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд нисэхийн мэргэжлээр бэлтгэгдсэн хүний нөөцийн чадавхыг бүрдүүлэх;

8.2.3.улсын нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалттай холбоотой мэдээллийн сан бүрдүүлэх, холбогдох байгууллагатай мэдээлэл солилцох;

8.2.4.улсын агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн гэрчилгээ, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ, нисэхийн мэргэжлийн үнэмлэх, зэрэг, зэрэглэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах;

8.2.5.улсын нисэхийн аэродромыг бүртгэх, гэрчилгээжүүлэх;

8.2.6.нислэгт тэнцэх чадварын гэрчилгээний хугацаа дууссан, нислэгт тэнцэх чадвараа алдсан улсын агаарын хөлгийн нислэгийг зогсоох, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

8.2.7.улсын нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалттай холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх;

8.2.8.Улсын нисэхийн багц дүрмээр зохицуулагдаагүй нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тодорхой хугацаатай шийдвэр гаргах, холбогдох этгээдэд мэдээлэх.

## 9 дүгээр зүйл.Цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын чиг үүрэг

9.1.Цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага улсын нисэхийн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.1.1.хилийн агаарын бүсэд нислэг үйлдэх зөвшөөрөлд хяналт тавих;

9.1.2.онцгой үүргийн нислэгийн зөвшөөрөл олгох;

9.1.3.байлдааны үүргийн, сургууль-байлдааны үүргийн нислэгийг төлөвлөж, гүйцэтгэх;

9.1.4.улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөнд хяналт тавих;

9.1.5.Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуулийн[5] 7.1-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

9.1.6.Зөвшөөрлийн тухай хуулийн[6] 8.2 дугаар зүйлийн 10.14-т заасан зөвшөөрлийг олгох.

**10 дугаар зүйл.Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын чиг үүрэг**

10.1.Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.1.1.нислэгийн үйл ажиллагааг хариуцсан нэгжтэй байх;

10.1.2.шалгагч зэрэглэлтэй нисгэгч, инженерийг томилох, чөлөөлөх;

10.1.3.Улсын нисэхийн багц дүрэм болон агаарын хөлгийн үйлдвэрлэгчээс гаргасан дүрэм, зааврын дагуу нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэх;

10.1.4.нислэгийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр бүх төрлийн арга хэмжээг зохион байгуулах;

10.1.5.нисэхийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, мэргэжлийн бүрэлдэхүүнийг сургах, хүний нөөцийг бүрдүүлэх;

10.1.6.энэ хуулийн 4.1.3-т зааснаас бусад улсын агаарын хөлөг, түүний нисэх багийн амь нас, эрүүл мэндийг даатгуулсан байх;

10.1.7.энэ хуулийн 14.1.2, 14.1.3, 14.1.4-т заасан нислэг үйлдэхэд зорчигчийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн даатгалыг гэрээ байгуулагч тал хариуцах.

10.2.Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага нисэх онгоц, нисдэг тэрэгний дадлагажуурдай байж болно.

10.3.Улсын нисэхийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах үүднээс улсын агаарын хөлгийг ашиглах гарын авлага, техник, технологийн болон бусад холбогдох баримт бичгийг тухайн үйлдвэрлэгч орны хэл дээр ашиглаж болно.

[5] Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2003 оны 23 дугаарт нийтлэгдсэн.
[6] Зөвшөөрлийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2022 оны 38 дугаарт нийтлэгдсэн.

10.4.Улсын агаарын хөлгийн засвар, техникийн үйлчилгээ болон нисэх баг, инженер техникийн бүрэлдэхүүний сургалтын тодорхой хэсгийг эдийн засгийн үр ашиг, чанар, аюулгүй байдлыг харгалзан дотоод болон гадаадын гэрчилгээжсэн хувийн хэвшлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болох бөгөөд түүнд тавигдах шаардлагыг Улсын нисэхийн багц дүрмээр зохицуулна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## УЛСЫН НИСЭХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИЦУУЛАЛТ

### 11 дүгээр зүйл.Улсын нисэхийн багц дүрэм

11.1.Улсын нисэхийн багц дүрмээр дараах харилцааг зохицуулна:

11.1.1.улсын агаарын хөлгийг бүртгэх, бүртгэлээс хасах, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах, хүчингүй болгох;

11.1.2.нисэхийн мэргэжлийн үнэмлэх, зэрэг, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах;

11.1.3.улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэх;

11.1.4.нисэхийн инженерийн албыг зохион байгуулах;

11.1.5.улсын нисэхийн аэродромын бүртгэл, ашиглалт, хангалтыг зохион байгуулах;

11.1.6.улсын агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа, аюулгүй байдалд хяналт тавих;

11.1.7.улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөний үйл ажиллагааг зохицуулах;

11.1.8.эрэн хайх, аврах ажиллагааг гүйцэтгэх;

11.1.9.улсын нисэхийн агаарын хөлгийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах;

11.1.10.нислэгийн дадлагажуурын цогцолборыг ашиглах;

11.1.11.цэргийн зориулалттай нисгэгчгүй нисэх хэрэгсэл, түүний удирдлагын системийг бүртгэх, гэрчилгээжүүлэх, ашиглах, хяналт тавих.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## УЛСЫН АГААРЫН ХӨЛӨГ, ТҮҮНД ХАМААРАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 12 дугаар зүйл.Улсын агаарын хөлгийн бүртгэл, нислэгт тэнцэх чадвар

12.1.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсад бүртгэх улсын агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн бүртгэлийг хөтөлнө.

12.2.Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага өөрийн өмчлөл, эсхүл эзэмшилд байгаа бусад улсад бүртгэлгүй агаарын хөлгийг Улсын нисэхийн багц дүрмийн дагуу улсын агаарын хөлгийн бүртгэлд бүртгүүлнэ.

12.3.Улсын агаарын хөлөг нислэгийн аюулгүй ажиллагааны нөхцөлийг хангасан нислэгт тэнцэх чадварын гэрчилгээтэй байна.

12.4.Энэ хуулийн 12.2-т заасны дагуу улсын агаарын хөлгийн бүртгэлд бүртгүүлээгүй, нислэгт тэнцэх чадварын гэрчилгээгүй улсын агаарын хөлгөөр нислэг үйлдэхийг хориглоно.

12.5.Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээнд түүний хүчинтэй хугацаа, агаарын хөлгийн зориулалт, нислэгийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай ангилал, хязгаарлалт болон бусад мэдээллийг тусгана.

12.6.Энэ хуулийн 10.1.6-д заасан даатгалыг улсын төсвийн санхүүжилтээр шийдвэрлэнэ.

### 13 дугаар зүйл.Улсын агаарын хөлгийн дарга, нисэх баг

13.1.Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага нь нислэгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор тухайн төрлийн нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэх шаардлага хангасан нисгэгчийг агаарын хөлгийн даргаар томилно.

13.2.Улсын агаарын хөлгийн дарга, нисэх багийн гишүүд нь батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон хүчин төгөлдөр мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээтэй байх бөгөөд жил бүр сунгаж баталгаажуулсан байна.

13.3.Агаарын хөлгийн дарга нислэгийн аюулгүй байдалд аюул тулгарсан тохиолдолд улсын агаарын хөлөгт байгаа зорчигчдын амь насыг

аврах зорилгоор нислэгийн төлөвлөгөө болон нислэгийн хөдөлгөөний удирдагчийн өгснөөс өөр шийдвэр гаргах эрхтэй.

13.4.Улсын агаарын хөлгийн дарга энэ хуулийн 14.1.1-д зааснаас бусад нислэгийг гүйцэтгэх үед Иргэний нисэхийн тухай хуулийн 21.3-т заасан эрхийг хэрэгжүүлнэ.

13.5.Байлдааны агаарын хөлгийн нисэх багийн гишүүд нь байлдааны үүргийн нислэг үйлдэх үед үнэмлэхийг улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын нуцын асуудал хариуцсан албан тушаалтанд хадгалуулна.

13.6.Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагад олон улсын болон Монгол Улсын иргэний нисэхийн байгууллагаар гэрчилгээжсэн, Улсын нисэхийн багц дүрмийн шаардлагыг хангасан Монгол Улсын болон гадаад улсын иргэнийг гэрээгээр ажиллуулж болно.

13.7.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрээгээр ажиллах гадаад улсын иргэн, хуулийн этгээдэд улсын агаарын хөлгөөр нисэх, техник үйлчилгээ хийх эрхийг дараах шаардлагыг үндэслэн олгоно:

13.7.1.мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ нь хүлээн зөвшөөрөгдсөн байх;
13.7.2.үндэсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ болон шалгалт хийгдсэн байх;

13.7.3.улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллагатай төрийн нуцын хууль тогтоомжийн дагуу нуцын баталгаа, нууц хадгалах гэрээ байгуулсан байх.

**14 дүгээр зүйл.Улсын агаарын хөлгийн нислэгийн ангилал**

14.1.Улсын агаарын хөлгийн нислэг дараах ангилалтай байна:

14.1.1.байлдааны үүргийн нислэг;
14.1.2.онцгой үүргийн нислэг;
14.1.3.тусгай үүргийн нислэг;
14.1.4.захиалгат нислэг;
14.1.5.сургууль-байлдааны нислэг;
14.1.6.шалгалт, туршилтын нислэг;
14.1.7.сургууль-дадлагын нислэг;
14.1.8.олон улсын нислэг.

14.2.Энэ хуулийн 14.1.1, 14.1.5-д заасан нислэгийг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын баталсан дүрмээр зохицуулна.

14.3.Улсын агаарын хөлгөөр захиалгат нислэг үйлдэх бол Иргэний нисэхийн тухай хууль болон холбогдох дүрмийг баримтална.

14.4.Улсын агаарын хөлгийг агаарт болон газарт шалгах, засвар, техникийн үйлчилгээ, тоног төхөөрөмж суурилуулсны дараа шалгалт, туршилтын нислэг үйлдэнэ.

14.5.Энэ хуулийн 14.1.2, 14.1.3, 14.1.4-т заасан нислэг, түүнтэй холбогдон гарах зардлыг тухайн захиалагч тал хариуцна.

14.6.Энэ хуулийн 14.1.2-т заасан нислэгийн аюулгүйн хамгаалалтыг хангах асуудлыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага болон төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хамтарсан журмаар зохицуулна.

**15 дугаар зүйл.Улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөний зохицуулалт**

15.1.Улсын агаарын хөлгийн байлдааны үүргийн нислэгийн хөдөлгөөний зохицуулалтыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын шийдвэрээр Агаарын цэргийн командлал хэрэгжүүлнэ.

15.2.Улсын агаарын хөлгийн онцгой болон тусгай үүргийн нислэгийн хөдөлгөөний зохицуулалтыг батлан хамгаалах болон иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтарсан журмаар зохицуулна.

15.3.Энэ хуулийн 14.1.4, 14.1.5, 14.1.6, 14.1.7, 14.1.8-д заасан нислэгийн хөдөлгөөнийг Улсын нисэхийн багц дүрмээр зохицуулна.

## ТАВДУГААР БҮЛЭГ
## УЛСЫН НИСЭХИЙН АЭРОДРОМЫН АШИГЛАЛТ

**16 дугаар зүйл.Улсын нисэхийн аэродром**

16.1.Улсын нисэхийн аэродромыг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасах, гэрчилгээ олгох, цуцлах, ашиглах, түүний бэлэн байдлыг Улсын нисэхийн багц дүрмээр зохицуулна.

16.2.Улсын нисэхийн зориулалттай аэродром нь батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гэрчилгээжсэн байна.

16.3.Улсын нисэхийн аэродромын аюулгүйн бүсийн орчимд үйлдвэрлэл, үйлчилгээ, барилга байгууламж барихыг хориглоно.

16.4.Улсын нисэхийн аэродромын аюулгүй байдал, ашиглалт, хамгаалалт, бэлэн байдал, аэродромыг техник, технологийн баримт бичигт зааснаар тоноглож, ашиглахыг улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага хариуцна.

**17 дугаар зүйл.Аэродромыг хамтран ашиглах**

17.1.Улсын болон иргэний нисэхийн зориулалтаар хамтран ашиглах аэродром нь иргэний нисэхийн аэродромд тавигдах шаардлагыг хангасан байна.

17.2.Улсын болон иргэний нисэхийн аэродромыг хамтран ашиглах харилцааг батлан хамгаалах болон иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтарсан журмаар зохицуулна.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ
## НИСЛЭГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, АЮУЛГҮЙН ХАМГААЛАЛТ

**18 дугаар зүйл.Улсын нисэхийн аюулгүй байдлын хяналт**

18.1.Улсын нисэхийн аюулгүй байдлын хяналт улсын агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдлын болон нислэгийн үйл ажиллагааны хяналтаас бүрдэнэ.

18.2.Улсын нисэхийн үйл ажиллагааг хариуцсан бүтцийн нэгжийн улсын хяналтын байцаагч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

18.2.1.эрх бүхий албан тушаалтнаас олгосон албаны үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг хэрэглэх;

18.2.2.албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой албан шаардлага, зөвлөмж, дүгнэлт гаргах, хэвлэмэл хуудас хэрэглэх;

18.2.3.хяналт шалгалт хийх зорилгоор улсын нисэхийн үйл ажиллагаатай холбоотой объект, барилга байгууламжид саадгүй нэвтрэх;

18.2.4.улсын нисэхийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийн хувийг шаардан гаргуулах;

18.2.5.шаардлагатай тохиолдолд улсын агаарын хөлгийг саатуулах;

18.2.6.холбогдох этгээдийн улсын нисэхийн баримт бичгийг түр хураах.

18.3.Цэргийн зориулалттай нисгэгчгүй нисэх хэрэгслийг энэ хуулийн 11.1.11-д заасан шаардлага хангаагүй тохиолдолд ашиглахыг хориглоно.

**19 дүгээр зүйл.Улсын нисэхийн аюулгүйн хамгаалалт**

19.1.Хуульд өөрөөр заагаагүй бол улсын нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангах чиглэлээр зорчигчийн бие, ачаа тээшинд агаарын хөлгийг ээмшигч болон мэргэжлийн байгууллага холбогдох дүрмийн дагуу үзлэг, шалгалт хийнэ.

19.2.Энэ хуулийн 19.1-д заасан үзлэг, шалгалт хийлгэхээс татгалзсан зорчигчийг тээвэрлэхийг хориглох ба шаардлагатай гэж үзвэл эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

19.3.Улсын агаарын хөлгөөр онцгой үүргийн нислэг үйлдэх үед аюулгүйн хамгаалалтыг хангах зорилгоор нисэх багийн бүрэлдэхүүнд хамгаалалтын ажилтныг ажиллуулж болно.

19.4.Улсын нисэхийн үйл ажиллагаанд ашиглах мэдээллийн технологи, навигаци, хяналт, нислэгийн удирдлагын систем нь кибер аюулгүй байдлын шаардлагад нийцсэн байна.

**ДОЛДУГААР БҮЛЭГ**
**УЛСЫН АГААРЫН ХӨЛГИЙГ ЭРЭН ХАЙХ, АВРАХ АЖИЛЛАГАА**

**20 дугаар зүйл.Эрэн хайх, аврах ажиллагаа**

20.1.Аюул тулгарсан болон аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлөг, түүний нисэх баг, зорчигчдыг эрэн хайх, аврах, тусламж үзүүлэх, тэдгээрийг ослын газраас шилжүүлэн зөөвөрлөх ажиллагааг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын удирдлага доор тухайн агаарын хөлөг ээмшигч байгууллагатай хамтран, тусгайлан бэлтгэгдсэн бие бүрэлдэхүүн, техник хэрэгсэл ашиглан гүйцэтгэнэ.

20.2.Улсын агаарын хөлгийг эрэн хайх, аврах ажиллагааг улсын болон иргэний нисэхийн байгууллага, холбогдох бусад байгууллагатай хамтран гүйцэтгэж болно.

20.3.Нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, аж ахуйн нэгж, иргэд аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлгийн талаар өөрт мэдэгдсэн

мэдээллийг зохих байгууллагад нэн даруй мэдэгдэх, нисэх баг, зорчигчдын амь насыг аврах, тэдэнд эмнэлгийн болон бусад зайлшгүй тусламж үзүүлэх, түүнчлэн агаарын хөлөг, түүний баримт бичгийг хамгаалалтад авах үүрэг хүлээнэ.

20.4.Энэ хуулийн 20.1-д заасан ажиллагааг Улсын нисэхийн багц дүрмээр зохицуулна.

**21 дүгээр зүйл.Аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлөг, нисэх баг, зорчигчдыг эрэн хайх, аврах ажиллагааг зогсоох**

21.1.Аюулд нэрвэгдсэн улсын агаарын хөлөг, нисэх баг, зорчигчдыг эрэн хайх бүх арга хэмжээ үр дүнгүй болсон тохиолдолд мэргэжлийн комиссын саналыг үндэслэн эрлийн ажлыг зогсоох шийдвэрийг Засгийн газар гаргана.

## НАЙМДУГААР БҮЛЭГ
## УЛСЫН НИСЭХИЙН НИСЛЭГ-ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ

**22 дугаар зүйл.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа**

22.1.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг агаарын хөлгийн осол, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох зорилгоор хэрэгжүүлнэ.

22.2.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа нь осол, зөрчлийг дахин давтагдахаас урьдчилан сэргийлнэ.

22.3.Энэ хуулийн 7.1.2-т заасны дагуу томилогдсон ерөнхий шинжээч нь нисгэгч, инженер, эсхүл шинжлэн шалгах чиглэлээр мэргэшсэн нисэхийн бусад мэргэжилтэй, хараат бус, бие даасан байна.

22.4.Улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага болон холбогдох бусад этгээд осол, зөрчилд өртсөн агаарын хөлөгтэй холбоотой эд мөрийн баримтыг шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэж дуусах хүртэл хадгалж, хамгаална.

22.5.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд оролцох албан тушаалтан нь агаарын хөлгийг эзэмшигч байгууллагын агаарын хөлгийг худалдан авахтай холбоотой

ажиллагаанд шууд болон шууд бус ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол худалдан авах ажиллагаанд оролцохоос татгалзана.

22.6.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд оролцох ерөнхий шинжээч, комиссын гишүүд нь улсын агаарын хөлгийг үйлдвэрлэгч болон засвар, техникийн үйлчилгээг хариуцах байгууллагатай ашиг сонирхлын зөрчилгүй эсэх талаар эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэнэ.

22.7.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны талаарх баримт, мэдээллийг устгах, өөрчлөх, нуун дарагдуулах, задруулахыг хориглоно.

22.8.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны нууцад хамаарахаас бусад мэдээлэл олон нийтэд нээлттэй байна.

**23 дугаар зүйл.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шалгах ерөнхий шинжээчийн эрх, үүрэг**

23.1.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шалгах ерөнхий шинжээч дараах эрхтэй:

23.1.1.албан үүргээ гүйцэтгэхдээ улсын агаарын хөлгийг эзэмшигч байгууллага болон шаардлагатай бусад газарт саадгүй нэвтрэх;

23.1.2.шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай мэдээлэл, судалгаа, тодорхойлолт болон бусад нотлох баримтыг холбогдох албан тушаалтан, хуулийн этгээдээс шаардан авах;

23.1.3.Улсын нисэхийн багц дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах;

23.1.4.улсын агаарын хөлгийн эзэмшигч байгууллагын нислэгийн бэлтгэл, гүйцэтгэлд үнэлэлт өгөх;

23.1.5.улсын нисэхийн техникийн ашиглалтын горимд хяналт тавьж, дүгнэлт гаргах, зөвлөмж өгөх.

23.2.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шалгах ерөнхий шинжээч дараах үүрэгтэй:

23.2.1.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааг зохион байгуулах;

23.2.2.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах, ангилах, бүртгэх ажиллагааг гүйцэтгэх;

23.2.3.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комиссын дүрмийн төслийг боловсруулах;

23.2.4.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчилтэй холбоотой мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийж, шалтгаан, нөхцөл, нөлөөлсөн хүчин зүйлсийн талаар тайлан гаргах.

**24 дүгээр зүйл.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комиссын чиг үүрэг**

24.1.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

24.1.1.улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчил болсон газарт саадгүй нэвтрэх, шинжлэн шалгах ажиллагаанд хамааралтай ослын үлдэгдэл, эд зүйлсийг хяналтад авах;

24.1.2.шинжлэн шалгах ажиллагааны явцад эд мөрийн баримтыг хамгаалах, агаарын хөлөг, түүний үлдэгдэл байгаа бүсэд зөвшөөрөлгүй этгээд нэвтрэх, эд зүйлс үрэгдэж гэмтэх, алдагдахаас хамгаалах боломжит бүх арга хэмжээг авах;

24.1.3.ослын газрыг хамгаалалтад авах асуудлыг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;

24.1.4.шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай ажиглагч, оролцогчийг томилох;

24.1.5.ослын газрын хамгаалалт буулгах, цаашид шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагагүй улсын агаарын хөлөг, түүний бүрдэл хэсэг, эд зүйлсийг хадгалалтаас чөлөөлөх;

24.1.6.шинжлэн шалгах ажиллагааны тайлан гаргах.

24.2.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийн шалтгааныг тогтоох, шинжлэн шалгах ажиллагаанд шаардлагатай тохиолдолд дотоод, гадаадын байгууллага, мэргэжилтнийг оролцуулж болно.

24.3.Улсын нисэхийн нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах комисс нь осол, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоож, цаашид осол, зөрчил гаргахгүй байх талаар холбогдох байгууллагад зөвлөмж хүргүүлнэ.

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ
## БУСАД ЗҮЙЛ

### 25 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

25.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль[7] болон Цэргийн албаны тухай хуульд[8] заасан хариуцлага хүлээлгэнэ.

25.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **С.БЯМБАЦОГТ**

[7] Төрийн албаны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 01 дугаарт нийтлэгдсэн.
[8] Цэргийн албаны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2016 оны 36 дугаарт нийтлэгдсэн.

# ᠳᠥᠷᠪᠡᠨ ᠳᠠᠪᠴᠠᠭᠠᠨ ᠤᠨᠳᠠᠰᠤᠨ ᠳᠤ ᠪᠤᠴᠠᠭᠠᠭᠳᠠᠪᠠᠯ ᠪᠤᠶᠤ ᠳᠤᠷᠠᠳᠴᠢᠯᠠᠯ ᠤᠨ ᠳᠤᠮᠳᠠ

# Хөдөлгөөнт зургийн хөгжлийг дэмжих сангаас олгох буцалтгүй тусламжийн тухай

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 98 дугаар тогтоолоор батлагдсан Хөдөлгөөнт зургийн хөгжлийг дэмжих сангаас олгох буцалтгүй тусламжийн журмын 3.1.2 дахь заалтыг доорх агуулгатай дараах хэлбэрээр өөрчлөв:

3.1.2. Хөдөлгөөнт зургийн бүтээлч, технологийн салбарт ажиллах хугацаа нь 5 (тав) ба түүнээс дээш жилийн туршлагатай, мэргэжлийн ур чадвартай, хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн;

3.1.3. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.4. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.5. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.6. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.7. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.8. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.9. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.10. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.11. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.12. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.13. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.14. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.15. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.16. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.17. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.18. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.19. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.20. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.21. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.22. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.23. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.24. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.25. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.26. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.27. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.28. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.29. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

3.1.30. Хөдөлгөөнт зургийн бүтээлийг бие даан гүйцэтгэсэн, мэргэжлийн ур чадвараа нотлох баримт бичгийг ирүүлсэн иргэн.

# Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгаар тогтоол

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгаар зүйлийн 24.1 дүгаар хэсгийн 24.1.1 дүгаар заалтыг баримтлан, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 1425 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2026 оны ажлын хөтөлбөрийн 1.1.1 дүгаар заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас доорх асуудлыг шийдвэрлэсэн нь:

1.1.1. Монгол Улсын Ерөнхий сайдын Тамгын газрын Ерөнхий сайдын Ажлын алба нь Монгол Улсын Ерөнхий сайдтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайдын Ажлын алба, Монгол Улсын Ерөнхий сайдын Ажлын алба дахь

٢.٠.٠.٤٠ مادة ٢٠٠٤ من قانون الإجراءات الجزائية – حجز المال من مادة إلى مادة. حجز المال من مادة إلى مادة. حجز المال من مادة إلى مادة. ٢٠٠٤ مادة ٢٠٠٤ من قانون الإجراءات الجزائية:

مصدره . تحديد الحجز:

٢.٠.٠.٤٠ مادة ٢٠٠٤ من قانون الإجراءات الجزائية – حجز المال من مادة إلى مادة. حجز المال من مادة إلى مادة. ٢٠٠٤ مادة ٢٠٠٤ من قانون الإجراءات الجزائية:

٢.٠.٠.٤٠ مادة ٢٠٠٤ من قانون الإجراءات الجزائية – حجز المال من مادة إلى مادة. حجز المال من مادة إلى مادة. ٢٠٠٤ مادة ٢٠٠٤ من قانون الإجراءات الجزائية:

٢ حجز حدد.. تسليم المال من مادة إلى مادة. حجز المال من مادة إلى مادة. ٢٠٠٤ مادة ٢٠٠٤ من قانون الإجراءات الجزائية:

٢.٠.٠ وجود رسوم مستحق سنتيمو سنتيمو مدرسة مدرسة من تسعة مدرسة حجز المال من مادة إلى مادة:

٢ حجز حدد.. وجود رسوم سنتيمو سنتيمو مدرسة مدرسة من تسعة مدرسة حجز المال من مادة إلى مادة:

٢.٠.٠.٤٠ مادة ٢٠٠٤ من قانون الإجراءات الجزائية – حجز المال من مادة إلى مادة. حجز المال من مادة إلى مادة. ٢٠٠٤ مادة ٢٠٠٤ من قانون الإجراءات الجزائية:

٢.٠.٠.٤٠ مادة ٢٠٠٤ من قانون الإجراءات الجزائية – حجز المال من مادة إلى مادة. حجز المال من مادة إلى مادة. ٢٠٠٤ مادة ٢٠٠٤ من قانون الإجراءات الجزائية:

٢.٠.٠ مدرسة / من تسعة من قانون الإجراءات الجزائية:

٢ حجز حدد.. مدرسة من تسعة من قانون الإجراءات الجزائية

٢.٠.٠ حجز المال من مادة إلى مادة. حجز المال من مادة إلى مادة. حجز المال من مادة إلى مادة. ٢٠٠٤ مادة ٢٠٠٤ من قانون الإجراءات الجزائية:

مصدره . تحديد الحجز:

٢.٠.٠ حجز المال من مادة إلى مادة. حجز المال من مادة إلى مادة. حجز المال من مادة إلى مادة. ٢٠٠٤ مادة ٢٠٠٤ من قانون الإجراءات الجزائية:

٢.٠.٠ حجز المال من مادة إلى مادة. حجز المال من مادة إلى مادة. حجز المال من مادة إلى مادة. ٢٠٠٤ مادة ٢٠٠٤ من قانون الإجراءات الجزائية:

٢.٠.٠ مدرسة / من تسعة من قانون الإجراءات الجزائية:

٢ حجز حدد.. مدرسة من تسعة من قانون الإجراءات الجزائية

٢.٠.٠ يحتفظ حدد.. يحتفظ حجز المال من مادة إلى مادة. حجز المال من مادة إلى مادة. ٢٠٠٤ مادة ٢٠٠٤ من قانون الإجراءات الجزائية:

- ᠬᠤᠪᠢᠳᠠᠯᠳᠠᠨ ᠳᠤᠷᠳᠠᠭᠳᠠᠭᠴᠢᠳ ᠪᠤᠶᠤ ᠳᠤᠷᠳᠠᠭᠳᠠᠭᠴᠢᠳ ᠨᠢ ᠬᠤᠪᠢᠳᠠᠯᠳᠠᠨ ᠳᠤᠷᠳᠠᠭᠳᠠᠭᠴᠢᠳ ᠳᠤ᠂

# Гүйцэтгэлийн дүн тооцоо, санхүүгийн тайлан

Өмнөх оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон 2025 оны санхүүгийн тайлан, гүйцэтгэлийн дүн тооцоо, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, тайлбар тэмдэглэлийг Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн журмын дагуу гаргаж, Монгол Улсын Аудитын тухай хуулиар батлагдсан аудитын стандартын дагуу аудит хийлгэсэн.

Аудитын дүгнэлт: Аудитлагдсан санхүүгийн тайлан нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн журмын дагуу бүтэн, зөв, шударга, бодитой гаргагдсан гэж үзсэн.

Гүйцэтгэлийн дүн тооцоо: Тайлант оны эхэнд 1,250.0 сая төгрөгтэй тэнцүү дүнтэй байсан гүйцэтгэлийн дүн тооцоо тайлант оны эцэст 1,310.0 сая төгрөгтэй тэнцүү дүнтэй гарсан нь 60.0 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Гүйцэтгэлийн дүн тооцоо: Тайлант оны эхэнд 1,250.0 сая төгрөгтэй тэнцүү дүнтэй байсан гүйцэтгэлийн дүн тооцоо тайлант оны эцэст 1,310.0 сая төгрөгтэй тэнцүү дүнтэй гарсан нь 60.0 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Гүйцэтгэлийн дүн тооцоо: Тайлант оны эхэнд 1,250.0 сая төгрөгтэй тэнцүү дүнтэй байсан гүйцэтгэлийн дүн тооцоо тайлант оны эцэст 1,310.0 сая төгрөгтэй тэнцүү дүнтэй гарсан нь 60.0 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Гүйцэтгэлийн дүн тооцоо: Тайлант оны эхэнд 1,250.0 сая төгрөгтэй тэнцүү дүнтэй байсан гүйцэтгэлийн дүн тооцоо тайлант оны эцэст 1,310.0 сая төгрөгтэй тэнцүү дүнтэй гарсан нь 60.0 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Гүйцэтгэлийн дүн тооцоо: Тайлант оны эхэнд 1,250.0 сая төгрөгтэй тэнцүү дүнтэй байсан гүйцэтгэлийн дүн тооцоо тайлант оны эцэст 1,310.0 сая төгрөгтэй тэнцүү дүнтэй гарсан нь 60.0 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Гүйцэтгэлийн дүн тооцоо: Тайлант оны эхэнд 1,250.0 сая төгрөгтэй тэнцүү дүнтэй байсан гүйцэтгэлийн дүн тооцоо тайлант оны эцэст 1,310.0 сая төгрөгтэй тэнцүү дүнтэй гарсан нь 60.0 сая төгрөгөөр нэмэгдсэн.

# ᠬᠣᠯᠪᠣᠭᠳᠣᠯ ᠳᠤᠮᠳᠠᠳᠤ ᠪᠣᠯᠣᠨ ᠳᠤᠮᠳᠠᠳᠤ ᠨᠢᠭᠡᠨᠳᠡᠭᠡᠷᠡᠬᠦ ᠪᠣᠯᠣᠨ ᠳᠤᠮᠳᠠᠳᠤ ᠨᠢᠭᠡᠨᠳᠡᠭᠡᠷᠡᠬᠦ᠄᠄

᠄᠄᠄

᠂᠂᠂

᠂᠂᠂

# Монгол Улсын Засгийн газрын тогтоол

## Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгаар сарын 14-ний өдрийн 14 дүгаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын гишүүдийн ажлын хуваарь батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгаар сарын 14-ний өдрийн 14 дүгаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын гишүүдийн ажлын хуваарь батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгаар сарын 14-ний өдрийн 14 дүгаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын гишүүдийн ажлын хуваарь батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгаар сарын 14-ний өдрийн 14 дүгаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын гишүүдийн ажлын хуваарь батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгаар сарын 14-ний өдрийн 14 дүгаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын гишүүдийн ажлын хуваарь батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгаар сарын 14-ний өдрийн 14 дүгаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын гишүүдийн ажлын хуваарь батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгаар сарын 14-ний өдрийн 14 дүгаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын гишүүдийн ажлын хуваарь батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгаар сарын 14-ний өдрийн 14 дүгаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын гишүүдийн ажлын хуваарь батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгаар сарын 14-ний өдрийн 14 дүгаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын гишүүдийн ажлын хуваарь батлах тухай

1723

/ᡳᡴᡳᡳᡴᡳᡳᡴᡳ

## Хөдөө гэрийн ажилчдыг хөдөлмөрлөлтөд дэмжих

Хөдөө гэрийн ажилчдыг хөдөлмөрлөлтөд дэмжих, ажлын байрны баталгаа, нийгмийн хамгаалалтыг сайжруулах, мэргэжлийн сургалтыг өргөжүүлэх, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, ажилчдын эрхийг хамгаалах, хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, хөдөлмөрлөлтийн зуучлалыг хөгжүүлэх, хөдөлмөрлөлтийн мэдээлэлтэй хангах, ажилчдын эрүүл мэндийг хамгаалах, ажилчдыг нийгмийн даатгалд хамрагдах, ажилчдыг ажлын байрны аюулгүй, эрүүл ахуйн нөхцөлтэй хангах, ажилчдыг ажлын байрны аюулгүй, эрүүл ахуйн мэдлэгтэй болгох

# Нэг хоногт хэдэн удаа мөрөн дээрх – хөндлөвч мөрөн дээрх – хөндлөвч мөрөн дээрх – хөндлөвч

# Хөдөлгүүрт тоормос суурилуулах, засварлах, ашиглалтын заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 456 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхийг зорьсон Хөдөлгүүрт тоормос суурилуулах, засварлах, ашиглалтын заавар батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Сайд Д.Ганбаатар, Монгол Улсын Сайд Ж.Ганхуяг, Монгол Улсын Сайд Ц.Мөнхцэцэг, Монгол Улсын Сайд Ц.Нарангэрэл, Монгол Улсын Сайд Ц.Оюунцэцэг, Монгол Улсын Сайд Ц.Сарантуяа, Монгол Улсын Сайд Ц.Цогзолмаа, Монгол Улсын Сайд Ч.Хишигсүрэн, Монгол Улсын Сайд Ш.Чинбат, Монгол Улсын Сайд Э.Бадмаанямбуу, Монгол Улсын Сайд Ю.Уртнасан, Монгол Улсын Сайд Я.Содбаатар, Монгол Улсын Сайд Х.Нямбаатар, Монгол Улсын Сайд Х.Баттөмөр, Монгол Улсын Сайд Х.Болорчулуун, Монгол Улсын Сайд Х.Хишиг-Очир, Монгол Улсын Сайд Х.Чулуунбаатар, Монгол Улсын Сайд Х.Эрдэнэбаяр, Монгол Улсын Сайд Х.Эрдэнэчимэг, Монгол Улсын Сайд Х.Ялалт, Монгол Улсын Сайд Ш.Түвшинжаргал, Монгол Улсын Сайд Ш.Хишигбаяр, Монгол Улсын Сайд Ө.Энхтүвшин, Монгол Улсын Сайд Ө.Энхтуяа, Монгол Улсын Сайд Ө.Ганзориг, Монгол Улсын Сайд Ө.Ганхуяг, Монгол Улсын Сайд Ө.Ганцогт, Монгол Улсын Сайд Ө.Ганчимэг, Монгол Улсын Сайд Ө.Ганчимэг, Монгол Улсын Сайд Ө.Ганчимэг

# ᠵᠠᠭᠤᠮᠵᠢ᠂ᠳᠤᠷᠠᠳᠴᠠᠯᠠᠭᠠᠨᠤᠨ ᠳᠤᠮᠳᠠᠳᠤ ᠪᠣᠯᠤᠨ ᠳᠤᠮᠳᠠᠳᠤ ᠪᠣᠯᠤᠨ ᠳᠤᠮᠳᠠᠳᠤ ᠪᠣᠯᠤᠨ ᠳᠤᠮᠳᠠᠳᠤ ᠪᠣᠯᠤᠨ᠂ᠳᠤᠷᠠᠳᠴᠠᠯᠠᠭᠠᠨ

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 06 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

## ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2003 оны 05 дугаар сарын 30-ны өдөр баталсан Улсын нисэхийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** **С.БЯМБАЦОГТ**

᠂᠂᠂

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 06 дугаар сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зэвсэгт хүчний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.23 дахь заалтын “6.2.3-т” гэснийг “9.1.2, 9.1.6-д” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Улсын нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА** **С.БЯМБАЦОГТ**

᠂᠂᠂

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны 06 дугаар сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

## ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хүнсний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

**1/3 дугаар зүйлийн 3.1.14 дэх заалт:**

"3.1.14."хоол үйлдвэрлэл, үйлчилгээ" гэж стандартын шаардлага хангасан байр, түүхий эд, бүтээгдэхүүн ашиглан, жор, технологийн дагуу техник, тоног төхөөрөмж, мэргэжлийн хүний нөөцөд тулгуурлан хоол үйлдвэрлэх, түүгээр үйлчлэх үйл ажиллагааг."

**2/4 дүгээр зүйлийн 4.1.5, 4.1.6 дахь заалт:**

"4.1.5.хүнсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаа шинжлэх ухаанд үндэслэсэн байх;

4.1.6.хүн, мал, амьтан, ургамлын эрүүл мэнд, байгаль орчны тэнцвэрт байдлын харилцан шүтэлцээг хангах."

**3/4 дүгээр зүйлийн 4.2, 4.3 дахь хэсэг:**

"4.2.Төрөөс хүнсний аюулгүй байдлыг хангах талаар дараах цогц бодлогын чиглэлийг баримтална:

4.2.1.хүнсний хангамж, хүртээмж, дотоодын үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хангах;

4.2.2.хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний аюулгүй байдлыг хангах;

4.2.3.шим тэжээллэг, чанартай хоол хүнсийг сонгон хэрэглэх боломжийг бүрдүүлэх, зөв зохистой хэрэглээг төлөвшүүлэх;

4.2.4.хүнсний аюулгүй байдлыг хангах үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бүрдүүлэх.

4.3.Энэ хуулийн 4.2-т заасан хүнсний аюулгүй байдлын бодлогыг удирдлага, зохион байгуулалт, хүний нөөц, мэдээлэл болон эрсдэлийн удирдлага, хяналтаар дамжуулан хэрэгжүүлнэ."

**4/5 дугаар зүйлийн 5.5-5.7 дахь хэсэг:**

"5.5.Хүн бүрийн эдийн засгийн боломж, газар зүйн байршил, нас, биеийн онцлог, хэрэгцээ, шаардлагад тохирсон хүнсийг тогтмол, хангалттай хэмжээнд авах боломжийг бүрдүүлэх замаар хүнсийг хүртээмжтэй байлгах арга хэмжээг Засгийн газар авч хэрэгжүүлнэ.

5.6.Энэ хуулийн 5.2, 5.3-т заасан хүнсний хангамжийг тодорхойлохдоо нэн тэргүүнд нялх, балчир хүүхдийн хоол тэжээл болон цэцэрлэг, сургуулийн хүнсний хүртээмжийн асуудлыг тусгана.

5.7.Энэ хуулийн 5.6-д заасан цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбогдсон харилцааг хуулиар зохицуулна."

**5/8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалт:**

"8.1.8.цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоол үйлдвэрлэлд дотоодын гарал үүсэлтэй түүхий эд ашиглан, стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан үйлдвэрт бэлтгэсэн хагас боловсруулсан болон бэлэн бүтээгдэхүүн нийлүүлсэн аж ахуйн нэгж, хоршоонд."

**6/10 дугаар зүйлийн 10.4, 10.5 дахь хэсэг:**

"10.4.Хүнсний чиглэлийн дараах үйл ажиллагаанд холбогдох стандарт, техникийн зохицуулалтыг дагаж мөрдөнө:

10.4.1.хүнсний анхан шатны болон боловсруулах үйлдвэрлэл, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хадгалалт, тээвэрлэлт, түгээлт, худалдаанд холбогдох стандарт, техникийн зохицуулалт;

10.4.2.хүнсний сав баглаа, боодол, туслах материалд хамаарах стандарт;

10.4.3.хүнсний экспорт, импорт, шошгололт, хадгалалт, хүргэлт, цахим болон бусад худалдаанд.

10.5.Энэ хуулийн 10.1.3-т заасан ажлыг Барилгын тухай хуульд заасны дагуу хийж гүйцэтгэнэ."

**7/13 дугаар зүйлийн 13.1.5, 13.1.6 дахь заалт:**

"13.1.5.хүнсний хангамж, бодит хэрэглээ, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний найрлагын судалгаа;

13.1.6.хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, шим тэжээл, молекул биологи, хүнсний нэмэлт, баяжуулах, зохицуулах үйлчлэлтэй хүнсний тандалт судалгаа.”

**8/13[1] дүгээр зүйл:**

“**13[1] дүгээр зүйл.Эрдэм шинжилгээний байгууллага**

13[1].1.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу эрдэм шинжилгээний байгууллагыг төрийн, хувийн, хамтарсан өмчийн хэлбэрээр байгуулж болно.

13[1].2.Энэ хуулийн 13[1].1-д заасан байгууллагад шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа эрхэлдэг хүрээлэн, төв, лаборатори, эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллага хамаарна.

13[1].3.Эрдэм шинжилгээний байгууллага хүнсний аюулгүй байдлыг хангах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

13[1].3.1.Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын төлөв байдлын судалгаа явуулж, нөхцөл байдлыг үнэлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох;

13[1].3.2.хүнсний бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн чиглэлээр үйлдвэрлэлийн технологийн туршилт, судалгаа явуулах, мониторинг хийх;

13[1].3.3.хүн амын эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн, байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи, ноу-хауг судалж, нутагшуулах талаар санал, зөвлөмж боловсруулах;

13[1].3.4.уламжлалт хүнс бэлтгэх арга технологийг сэргээн таниулах, инновац шингэсэн бүтээгдэхүүнийг бий болгох, хэрэглээнд нэвтрүүлэх;

13[1].3.5.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний сав, баглаа, боодол, хадгалалт, тээвэрлэлт, түгээлтийн шинэ технологийг нэвтрүүлэх талаар зөвлөмж гаргах;

13[1].3.6.хүнсний салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх;

13[1].3.7.шим тэжээллэг, аюулгүй хүнсийг сонгон хэрэглэх, зохистой хооллох талаар олон нийтийг соён гэгээрүүлэх, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

$13^1$.3.8.энэ хуулийн 13.1.1, 13.1.5, 13.1.6-д заасан тандалт судалгааг гурваас таван жил тутамд явуулж, үр дүнг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд тайлагнах, холбогдох төрийн байгууллага болон нийтэд мэдээлэх;

$13^1$.3.9.хуульд заасан бусад.

$13^1$.4.Төсөл, судалгаа хөгжүүлэлтийн ажлын санхүүжилтийг Шинжлэх ухаан, технологийн тухай хуулиар зохицуулна.”

**9/$13^2$ дугаар зүйл:**

“**$13^2$ дугаар зүйл.Салбарын хүний нөөцийн удирдлага**

$13^2$.1.Салбарын хүний нөөцийг төлөвлөх, бүрдүүлэх, давтан сургах, мэргэшүүлэхэд чиглэсэн бодлого, арга хэмжээг улсын хэмжээнд хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн хэмжээнд тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга хэрэгжүүлнэ.

$13^2$.2.Энэ хуулийн $13^2$.1-д заасан байгууллага, албан тушаалтан нь хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх чиглэлээр их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллага, лаборатори болон мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана.

$13^2$.3.Хүнсний салбарын мэргэшлийн зэрэг олгох журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

$13^2$.4.Энэ хуулийн $13^2$.3-т заасан журамд мэргэшлийн зэргийн төрөл, хэлбэр, хугацаа, мэргэшүүлэх чиглэл, тавих шаардлага, сургалтын багц цаг болон зэрэг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг тусгана.

$13^2$.5.Энэ хуулийн $13^2$.4-т заасан мэргэшлийн зэрэг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэрийг хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргах бөгөөд мэргэжилтэн уг шийдвэрийн талаар хуульд заасан журмын дагуу гомдол гаргах эрхтэй.”

**10/$17^1$ дүгээр зүйл:**

“**$17^1$ дүгээр зүйл.Хүнсний салбарын мэдээллийн нэгдсэн сан**

$17^1$.1.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүнсний аюулгүй байдлыг хангах, салбар хоорондын үйл

ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтөлнө.

17[1].2.Хүнсний салбарын мэдээллийн нэгдсэн сан дараах мэдээллээс бүрдэнэ:

17[1].2.1.хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэл;

17[1].2.2.гол нэрийн хүнсний нөөцийн мэдээлэл;

17[1].2.3.баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнс, хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний бүртгэл;

17[1].2.4.хяналт шалгалтын тайлан;

17[1].2.5.импорт, экспортын зөвшөөрөл, гүйцэтгэлийн мэдээлэл;

17[1].2.6.энэ хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулалт хийсэн талаарх мэдээлэл;

17[1].2.7.хүнсний сорилтын лабораторийн шинжилгээний дүн;

17[1].2.8.хүнсний салбарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан.

17[1].3.Төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн санг бүрдүүлэх харилцааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.10, 27.9-д заасны дагуу зохицуулна.

17[1].4.Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, мэдээлэл ашиглах, цуглуулах, хэлбэр, хугацаа, мэдээллийн ил тод байдал, нууцлал, аюулгүй байдлыг хангах, хадгалах, хамгаалах, эрхлэн хөтлөхтэй холбогдсон журмыг Засгийн газар батална.”

**2 дугаар зүйл.**Хүнсний тухай хуулийн 5 дугаар зүйлийн гарчгийн “тодорхойлох” гэсний дараа “, бүрдүүлэх” гэж, мөн зүйлийн 5.2 дахь хэсгийн “хангамжийг” гэсний дараа “улсын хэмжээнд” гэж, 6 дугаар зүйлийн гарчгийн “нөөц” гэсний дараа “бүрдүүлэх” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Хүнсний тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/5[1] дүгээр зүйл**:

**“$5^1$ дүгээр зүйл.Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох**

$5^1$.1.Хүн амын хүнсний хэрэгцээг дотоодод үйлдвэрлэсэн хүнсээр нэн тэргүүнд хангах, уг хэрэгцээг хангах боломжгүй тохиолдолд стратегийн хүнсийг импортлоно.

$5^1$.2.Энэ хуулийн $5^1$.1-д заасан хүнсний хэрэгцээнээс илүү гарсан дотоодод үйлдвэрлэсэн стратегийн хүнсийг экспортолж болно.

$5^1$.3.Хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн $5^1$.1, $5^1$.2-т заасан экспорт, импортын урьдчилсан тооцоо судалгаанд үндэслэн тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний талаарх саналыг энэ хуулийн 18.1-д заасан Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд танилцуулна.

$5^1$.4.Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн $5^1$.3-т заасан Засгийн газрын гишүүний саналыг дараах цаглаврын дагуу Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөлд хүргүүлэх ажлыг зохион байгуулна:

$5^1$.4.1.сүүний тоо хэмжээний талаарх саналыг жил бүрийн 06 дугаар сарын 10-ны дотор;

$5^1$.4.2.малын махны тоо хэмжээний талаарх саналыг жил бүрийн 09 дүгээр сарын 10-ны дотор;

$5^1$.4.3.гурил, тарианы үр, хүнсний улаан буудай, ундны усны тоо хэмжээний талаарх саналыг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор.

$5^1$.5.Энэ хуулийн $5^1$.3-т заасны дагуу ирүүлсэн Засгийн газрын гишүүний саналыг Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл хэлэлцээд дараах санал, зөвлөмжийн аль нэгийг гаргана:

$5^1$.5.1.тухайн жилд экспортлох, импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээний талаарх саналыг бүхэлд нь дэмжих, эсхүл хүнсний нэр төрлийг өөрчлөх, тоо хэмжээг бууруулах;

$5^1$.5.2.тухайн жилд стратегийн хүнсийг экспортлох, импортлох хугацааг хойшлуулах;

$5^1$.5.3.хүн амын хүнсний хангамж, үнийн түвшинг тогтвортой хадгалах зорилтын хүрээнд стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээнд хязгаар тогтоохгүй байх;

